



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 35

Чингис хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 16, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3, 2.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Өмнөдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн өргөдлийг хянан шалгасан дүгнэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Эрүүл мэнд Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 106 дугаар тушаалаар батлагдсан Ээлжийн амралт олгох зааврын дагуу ээлжийн амралт олгох Засаг даргын захирамж гараагүй байхад ээлжийн амралт биеэр эдэлсэн Л.Баярмаад холбогдох Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Б/05 дугаартай “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” захирамж нь хууль зүйн үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР